



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/212

Булган сум

Газар өмчлөх эрх хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын 6 дугаар баг, Залуус 9 дүгээр гудамжны 908 тоотод байрших, 6308002779 нэгж талбарын дугаартай, эзэмшлийн зориулалттай газрыг иргэн Сүрэнхорлоогийн Юмжав (АЭ81021462)-д аймгийн Засаг даргын 2008 оны 156 дугаар захирамжаар өмчлөх эрхээр давхардуулан олгосон тул уг захирамжийн С.Юмжавтай холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

2. Дээрх зөрчлийг арилгаж, газар өмчлөлийн улсын бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010289

Сугар Ажил 2026 өдөр бүр Дос/2026/Захирамж